

ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ АЛБАН ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХТЭЙ НЬ ХОЛБОГДУУЛАН АЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СУБЪЕКТИВ ТАЛ

THE SUBJECTIVE ASPECT OF THE CRIME OF MURDERING A LAW ENFORCEMENT OFFICER IN CONNECTION WITH THEIR OFFICIAL DUTIES

В.Амарсанаа

*ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Инновацын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш,
доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

Э.Буман-Аюуш

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Дотоодын цэргийн албаны тэнхимийн
ахлах багш, ахмад*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд хууль сахиулагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан алах гэмт хэргийн субъектив талыг эрүүгийн эрх зүйн онол, практикийн үүднээс судлахыг зорилоо. Тодруулбал, Монгол Улсын Эрүүгийн хуулийн одоогийн зохицуулалт (10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэг) нь тухайн гэмт хэргийг “албан үүрэгтэй нь холбогдуулж” гэсэн ерөнхий нэр томъёогоор хязгаарлаж байгааг онцолж, гэмт этгээдийн зорилго, сэдлийг тодорхой тусгах шаардлагыг эрэлхийллээ.

Abstract: This article aims to investigate the subjective aspect of the crime of murdering a law enforcement officer in connection with their official duties, from the perspective of criminal law theory and practice. Specifically, it highlights that the current legal framework of the Mongolian Criminal Code (Article 10.1, Section 2.9) limits this offense to a general term, "in connection with their official duties," and seeks to address the imperative need to explicitly define the perpetrator's intent and motive.

Түлхүүр үгс: Эрхэлж байгаа ажил, албан үүрэг, субъектив тал, хууль сахиулагч.

Keywords: Official duties, Subjective aspect, Law enforcement officer.

Оршил

Монгол Улсын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талыг тодорхойлох нь онолын болон практикийн хувьд чухал ач холбогдолтой хэдий ч судлаачдын дунд нэгдсэн ойлголт, үзэл баримтлал хараахан тогтоогүй байна. Гэмт хэргийн дотоод агуулга, мөн чанарыг илэрхийлэх субъектив талыг зөвхөн гэм буруугийн хүрээнд хязгаарлах нь сэдэл, зорилго, сэтгэл хөдлөл зэрэг бусад нэмэлт шинжүүдийг орхигдуулах эрсдэлтэйг профессор С.Жанцан, Г.Гантөмөр нарын бүтээлүүд онцолж, гэмт хэргийн субъектив талыг эдгээр шинжүүдийн цогц нэгдэл хэмээн үзэх нь илүү оновчтой болохыг харуулсан.

Ялангуяа, хууль сахиулагчийн амь биед халдах гэмт хэргийг зүйлчлэх, ял шийтгэл оногдуулахад гэмт этгээдийн сэдэл, зорилгыг нарийвчлан тогтоох нь Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэхэд нэн чухал юм. Одоогийн Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэгт “эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь, түүний ойр дотны хүнийг алах” хэмээн заасан нь тухайн үйлдлийн зорилго, сэдэлтийг тодорхой тусгалгүйгээр зөвхөн үүрэг гүйцэтгэж буй байдалтай нь холбогдуулсан хэлбэрээр томъёологдсон нь учир дутагдалтай болохыг практик болон онолын үүднээс шүүмжлэх үндэслэлтэй. Энэ нь гэмт хэргийг зүйлчлэх, ял шийтгэл оногдуулах явцад олон тооны

эргэлзээ, хүндрэлийг үүсгэж, ялангуяа гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа, гэмт этгээдийн жинхэнэ зорилго, сэдэлт зэргийг бүрэн дүүрэн тусгаж чадахгүйд хүргэж байна.

Иймд хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектив талын онолын асуудлыг судлан, зорилго, сэдлийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох шаардлагатай байна.

Үндсэн хэсэг

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектив талыг гэмт хэргийн дотоод агуулга, мөн чанарын бодит илэрхийлэл гэх байдлаар ерөнхийлөн тодорхойлох явдал түгээмэл боловч субьектив талын тухай судлаачид янз бүрээр тайлбарласан байдаг. Профессор Б.Содовсүрэн “...субьектээс нийгэмд аюултай өөрийн үйлдэл, тэрхүү үйлдлээс учирсан хор хөнөөлтэй харьцсан сэтгэхүйн харьцааны илрэл” (Содовсүрэн, 1998) хэмээн гэм буруугийн тодорхойлолттой адилаар тайлбарласныг профессор С.Жанцан “субьектив тал нь гэм буруугаас өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд гэм буруу нь түүний нэг бие даасан заавал байх шинж” (Жанцан, С., 2009, хууд. 462) гэж шүүмж илэрхийлсэн. Энэ тал дээр профессор С.Жанцангийн үзэл санаа илүү оновчтой. Хэрэв гэмт хэргийн субьектив талыг зөвхөн гэм буруугийн тухай ойлголтын хүрээнд тайлбарлавал, бусад шинжүүд орхигдох талтай.

Академич С.Нарангэрэлийн “Гэмт хэргийн субьектив талын агуулга нь гэм буруутай этгээдээс өөрийн үйлдсэн нийгэмд аюултай хэрэгт харьцсан сэтгэхүйн харьцаа мөн... Гэмт хэрэг үйлдэхэд дагалддаг сэтгэл санаа, хүсэл зориг, сэтгэл хөдлөлийн харилцан уялдаа, нэгдэл бүхий сэтгэцийн үйл ажиллагаа” (Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги., 1999) гэж тайлбарласантай профессор С.Жанцан санал нэгдэхгүй байгаагаа илэрхийлээд, “...субьектийн оюун санаа, хүсэл зориг нь гэмт хэрэг үйлдэх явдлыг дагалдах бус, өдөөн түлхэгч, өөрөөр хэлбэл, анхдагч сэтгэхүйн үйл явц” гэж тайлбарлаад, гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектив талыг “Нарийвчилсан утгаараа, гэм буруу, сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл санааны байдал (сэтгэл хөдлөл) зэрэг үндсэн ба нэмэгдэл шинжүүдээр тодорхойлогддог, субьектийн ухамсар, хүсэл зоригт тусгагдсан сэтгэцийн үйл явцын талаарх ухагдахууныг илэрхийлдэг, гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг үндсэн элемент буюу субьектив шинж” (Жанцан, С., 2009, хууд. 466) хэмээн үзсэн.

Харин профессор Г.Гантөмөр “Гэмт хэрэг нь хүний тодорхой ухамсартай үйл ажиллагаа бөгөөд түүний илрэх гадаад хэлбэр болох хүний нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл, түүнээс уламжлан бий болсон объектив шинжтэй үр дагавар, бодит өөрчлөлт, (объектив тал) түүнтэй салшгүй холбоо бүхий хүний үйл ажиллагааг төрүүлж, жолоодож, удирдаж байгаа сэтгэхүйн үйл ажиллагаа (субьектив тал)-ны илрэл юм. Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал нь гэмт этгээдийн гэмт үйл ажиллагааны илрэх гадаад хэлбэрийг тодорхойлдог бол субьектив тал нь гэмт этгээдийн өөрийн нийгэмд аюултай гэмт хэрэгтээ хандсан сэтгэл зүйн дотоод харьцааг илэрхийлнэ” (Гантөмөр Г., Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол., 2011) хэмээн гэмт хэргийн объектив талтай хамааруулан авч үзсэнээс гадна субьектив тал нь объектив талтай хамтран оршиж байж сая нэг энэ (субьектив талын тухай) тодорхойлолт нь үнэнд нийцэхийг харуулснаараа ач холбогдолтой. Энэ нь түүний ашигласан “сэтгэхүйн үйл ажиллагаа”, “салшгүй холбоо”, “сэтгэл зүйн дотоод харьцаа” зэрэг нэр томъёоноос харагддаг. Эдгээр (объектив болон субьектив) талуудын салшгүй холбоотой байдал нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.3 дугаар зүйл (Хэрэг хариуцах чадвар)-ийн 2 дахь хэсэгт заасан “Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно” хэмээх тайлбараас тодорхой харагддаг.

Гэмт этгээдийн үйлдэл болон гэм бурууг илэрхийлэх сэдэлт, зорилго зэргийн харилцан хамаарлын чухал байдлын талаар Демокритын “Үйл хэргийн ёс суртахууны үнэ

цэнийг тодорхойлохдоо хүсэл зориг ба үйлдлийн нэгдэл буюу хийгдэж буй үйлдлийн субъектив болон объектив талуудын нэгдмэл байдлыг харгалзан үзэх шаардлагатай”. “Сайн хүн байна гэдэг нь зөвхөн шударга бус зүйл хийхгүй байхыг хэлэхгүй, мөн тийм зүйл хүсэхгүй байхыг хэлнэ... Шударга, шударга бус хүнийг түүний хийсэн зүйлээс гадна юу хүсэж байгаагаар нь таньж мэднэ” гэж хэлсэн үг маш оновчтой.

Гэмт хэргийн субъектив тал нь зөвхөн гэм буруугаар хязгаарлагдахгүй, харин сэдэл, зорилго, сэтгэл хөдлөл зэрэг сэтгэцийн нарийн төвөгтэй үйл явцуудын цогц нэгдэл болох С.Жанцан, Г.Гантөмөр нарын үзэл баримтлал нь гэмт хэргийн дотоод мөн чанарыг илүү гүнзгий тусгаж, зүйлчлэл болон ял шийтгэл оногдуулах суурийг илүү оновчтой байдлаар тавьсан байна.

Эрүүгийн хуульд гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын үндсэн шинж болох гэм бурууг “Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцно” (Эрүүгийн хууль, 2015) хэмээн зааснаас үзэхэд, гэм буруу нь аливаа үйлийг гэмт хэрэгт тооцоход заавал байх үндсэн шинж болох нь харагдаж байна.

Хууль сахиулагчийг эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь, түүний ойр дотнын хүнийг алах гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгддэг. Тодруулбал, гэмт этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж, түүнээс учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдаас мэдсээр атал хүссэн, эсвэл хүсээгүй боловч тэр хор уршигт зориуд хүргэсэн байхыг гэм буруугийн санаатай хэлбэр гэнэ. Энэ гэмт хэрэгт заавал тодорхойлох шаардлагатай нэг зүйл нь гэмт хэргийн субъектив талын үндсэн шинж (гэм буруу)-ээс гадна гэмт этгээдийн зорилго байдаг бөгөөд энэ нь тухайн үйлдлийг зөв зүйлчилж, зохих ял шийтгэл оногдуулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.

Хууль тогтоогч хууль сахиулагчийг алах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэгт бүтэцлэхдээ зорилго, сэдэлтийг диспозицод тодорхой тусгалгүй, зөвхөн “эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь, түүний ойр дотны хүнийг алах” хэмээн хүнийг алах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлаар хуульчилж, хууль сахиулагчийг албан үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбоотойгоор түүнийг болон ойр дотны хүнийг нь алсан этгээдэд энэ зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэх гагц холбоонд суурилснаараа учир дутагдалтай. Хэрэв гэмт этгээд хууль сахиулагчийн хууль ёсны үйл ажиллагаанд өс хонзон санаж, улмаар үүрэг гүйцэтгэснээс нь хойших цаг хугацаанд, жишээлбэл, алба хаагч тэтгэвэртээ суусан хойно нь түүнийг алсан бол энэ зүйлээр зүйлчлэх боломжтой эсэх тал дээр эргэлзээ төрж байна. Тиймээс эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд зорилго, сэдэлт хэмээх гэмт хэргийн субъектив талын нэмэгдэл шинжүүдийг судлах шаардлагатай.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэгт хууль сахиулагчийг алах гэмт хэргийн үүднээс гэмт этгээдийн сэдэл, зорилгыг тусгаагүй нь ОХУ-ын Эрүүгийн хуульд энэхүү гэмт хэргийг хэрхэн томьёолсон, мөн холбогдох заалтууд хэрхэн тайлбарлагддаг тухай гүнзгийрүүлсэн судалгаа хийх зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Энэ нь эрүүгийн эрх зүйн онол, практикт, ялангуяа уг гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив болон субъектив талуудын уялдаа холбоог тодорхойлоход чухал ач холбогдолтой. Энэхүү харьцуулсан дүн шинжилгээ нь хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийг нарийвчлан тодорхойлоход сэдэл, зорилгын үүргийг ойлгоход чухал хувь нэмэр оруулах болно.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйл (Хууль сахиулах байгууллагын алба хаагчийн амь насанд халдах)-ийн диспозицод “Хууль сахиулах байгууллагын ажилтан, цэргийн албан хаагчийн нийгмийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль ёсны үйл ажиллагаанд нь саад учруулах зорилгоор эсхүл ийм үйл ажиллагааны төлөө өшөө авах зорилгоор тэдний болон ойр дотны хүмүүсийн

амь насанд халдсан бол” (Уголовный кодекс РФ, 1996) хэмээн “нийгмийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль ёсны үйл ажиллагаанд нь саад учруулах” болон “ийм үйл ажиллагааны төлөө өшөө авах зорилгыг зүйл, заалтад шууд хуульчилжээ. Уг зорилго, сэдэл нь тухайн гэмт хэргийг үйлдэгдсэнд шууд тооцоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх бөгөөд эдгээр шинжүүд байгаа тохиолдолд уг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн хангадаг.

Профессор З.А. Незнамовагийн үзэж байгаагаар, саад учруулах гэдэг нь “ирээдүйд энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэхэд саад хийх, таслан зогсоох оролдлого” (Козаченко бас бус., 1998, хууд. 671) ажээ. А.Ю. Кизиловын тодорхойлсноор, “гэмт хэрэгтэн төрийн эрх мэдлийн итгэмжлэгдсэн этгээд болон тэдний ойр дотнын хүмүүст хүчирхийлэл үйлдэхдээ ийм үйл ажиллагааг ихээхэн сарниулах, эсвэл бүрмөсөн зогсоохыг эрмэлздэг” (Кизилов, 2002, хууд. 79) бол А.Р. Саруханян “Зорилго нь нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагааны мөн чанарыг өөрчлөх, эсвэл бүрмөсөн зогсооход оршино” (Саруханян, 2003, хууд. 44) гэж үздэг. И.В. Шишкогийн үзэж байгаагаар, “Саад учруулах зорилго нь тодорхой үйлдлүүдийг гүйцэтгүүлэхгүй байх гэсэн гэмт хэрэгтний санаа зорилго” (Шишко, хууд. 684) байдаг бол А.В. Шабанов “Гэмт этгээдийн тусгай зорилго нь нийгмийн хэв журам хамгаалах, нийгмийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны мөн чанарыг ямар нэгэн байдлаар өөрчлөхөд оршино” (Шабанов, 2003, хууд. 100) гэж үздэг. ОХУ-ын Эрүүгийн хуулийн тайлбарт: “Хууль сахиулах байгууллагын ажилтан эсвэл нийгмийн хэв журам хамгаалах, нийгмийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй цэргийн албан хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах зорилго гэдэг нь гэмт хэрэгтэн эдгээр этгээдийн дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг таслан зогсоох (ирээдүйд үүнийг гаргуулахгүй байх) эсвэл зогсоох (одоогийн байдлаар тасалдуулах) эрмэлзлийг хэлнэ” (Боженок, 2017, хууд. 805) хэмээн тайлбарлажээ.

Харин ОХУ-ын Дээд шүүхийн президиумын 2005 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн №229 тогтоолын 5 дугаар зүйлд хууль сахиулах байгууллагын ажилтнуудын нийгмийн хэв журам хамгаалах, нийгмийн аюулгүй байдлыг хангах хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулахыг – энэ гэмт хэргийн зорилго гэж тодорхойлоод, “одоо, эсвэл ирээдүйд ийм үйл ажиллагааг таслан зогсоох, өөрчлөх эрмэлзэл” (Постановление Президиума Верховного Суда РФ, 2005) гэж тайлбарласан байдаг.

Тэгэхээр хууль сахиулах байгууллагын ажилтны нийгмийн хэв журам болон аюулгүй байдлыг хамгаалах хууль ёсны үйл ажиллагаанд нь саад учруулах зорилго нь тухайн үйл ажиллагааг ирээдүйд биелэгдэх боломжийг таслан зогсоох, уг үйл ажиллагааг ноцтойгоор сарниулах, эсвэл бүрмөсөн зогсоохыг эрмэлзэх зэрэг утгыг агуулдаг байна. Дээр дурдсан эрдэмтдийн болон тогтоолуудад тусгагдсан байр сууриудтай бид бүрэн санал нийлж байгаа хэдий ч, ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлийн диспозицид тусгагдсан “хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах” гэх тусгай зорилго нь нэг талаас, гэмт үйлдлийн зорилго чиглэсэн шинж чанарыг илэрхийлдэг бөгөөд энэ тохиолдолд өөрөө зорилго бус, харин эцсийн үр дүнд хүрэх хэрэгсэл болдог.

Нөгөө талаас, энэхүү зорилго нь өмнө үйлдсэн гэмт хэрэг болон зөрчилд хүлээлгэх хариуцлагаас зайлсхийх зорилгоор амь насанд халдахыг өөртөө багтаадаггүй ойлголт юм. Тиймээс хууль сахиулагчийг алах гэмт хэргийн диспозицод “урьд үйлдсэн гэмт хэрэг болон зөрчилд хүлээлгэх хариуцлагаас зайлсхийх” хэмээх зорилгыг нэмэлтээр хуульчлах шаардлагатай. Энэхүү шинэ нэмэлт нь шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргүүдийн шинжилгээгээр батлагддаг. Тухайлбал, Иргэн Т.Лундаа нь Б.Энхбаяртай бүлэглэж, 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 12 цагийн үед Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороо, Бэлхийн 36-105 тоот хашааны гадна талд 04-96 УБР улсын дугаартай “Тоёота ланд круйзер прадо-95” маркийн автомашиныг тус дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн Бэлх-114 чиглэлд үүрэг гүйцэтгэж байсан эргүүлийн офицер, цагдаагийн ахмад Д.Батчулуун, цагдаа жолооч, цагдаагийн ахлах ахлагч Д.Батсайхан нарыг шалгахад, хууль ёсны шаардлагыг нь

эсэргүүцэн, зугтаахдаа цагдаагийн ахлах ахлагч Д.Батсайханыг автомашинаас зүүгдэн явахыг мэдсээр байж Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Өвөр согоотын эцсийн буудлын засмал зам дээр унагааж, амь насыг нь хохироосон гэмт хэрэгт холбогдсон (Шүүхийн шийтгэх тогтоол, 2019, хууд. 2).

Иргэн Т.Лундаад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.9 (эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь, түүний ойр дотны хүнийг...), 2.11 (бүлэглэж...) дэх хэсэгт тус тус зааснаар 13 жилийн хорих ял, харин иргэн Б.Энхбаярт мөн зүйлийн мөн хэсгүүдэд зааснаар 15 жилийн хорих ялыг тус тус оноожээ (Шүүхийн шийтгэх тогтоол, 2019, хууд. 36). Эдгээр этгээд нь өмнө залилах гэмт хэрэг үйлдэж, цагдаагийн байгууллагад шаллагдаж байсан бөгөөд урьд үйлдсэн залилах гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагаас зайлсхийх зорилгоор автомашинтайгаа зугтаасан үйлдлийн үр дүнд цагдаагийн алба хаагчийн амь нас хохирсон байдаг.

Дээр дурдсан онолын болон практикийн дүн шинжилгээний үр дүнд үндэслэн, хууль сахиулагчийн амь биед халдах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тогтолцоонд шинээр хуульчилж, уг зүйлийн диспозицид “нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль ёсны үйл ажиллагаанд нь саад учруулах” болон “урьд үйлдсэн гэмт хэрэг, зөрчилд хүлээлгэх хариуцлагаас зайлсхийх” хэмээх зорилгуудыг багтаах нь уг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг илүү нарийвчлан тодорхойлж, эрүүгийн эрх зүйн шударга ёсыг хангахад чухал ач холбогдолтой. Энэ нь гэмт хэрэгтний үйлдлийн зорилгыг бүрэн дүүрэн тусгаж, шүүхийн практикийг нэг мөр болгоход хувь нэмэр оруулна.

Хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийн сэдлийг оновчтой тогтоох нь уг гэмт хэргийн зорилгыг тодорхойлохоос дутуугүй ач холбогдолтой. Эрүүгийн хуульд шууд заагдсан, өрсөлдөх хэм хэмжээнүүдийг хооронд нь ялгах, хувь хүний гэм буруугийн зэргийг тодорхойлох, түүний санаа, зорилгын чиглэл, үйлдлийнх нь жинхэнэ санааг тогтооход туйлын шаардлагатай сэдэл, зорилгыг судлах нь зүйтэй (Векленко & Бавсун, 2006, хууд. 84).

Эрүүгийн эрх зүйд гэмт үйлийг зөвхөн объектив талаас нь бус, харин гэмт этгээдийн дотоод сэтгэл зүй, оюун санааны байдлыг (субъектив тал) харгалзан үнэлэх нь гэм буруугийн зарчмыг баримтлах, ял шийтгэл оногдуулахдаа шударга ёсыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү субъектив талын гол бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг нь сэдэл бөгөөд энэ нь тухайн үйлдлийг хийхэд хүргэсэн дотоод хөдөлгөгч хүч юм (Самундра & Бямбадорж, 2021). Эрүүгийн хуульд сэдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх шинж, эсвэл ялыг хүндрүүлэх нөхцөл байдал байж болох бөгөөд ижил төстэй үйлдлүүд ч гэсэн өөр өөр сэдэлтэй бол ялгаатай үнэлэгддэг.

Эрүүгийн эрх зүйн онолд сэдэл нь гэмт хэргийг төсөөтэй үйлдэл (эс үйлдэхүй)-ээс ялган зүйлчлэхээс гадна гэмт этгээдийн туйлын санааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэдийгээр сэдэл нь гэмт хэргийн субъектив талын нэмэлт шинжид хамаардаг боловч зарим гэмт хэргийн диспозицид шууд заагдсан тохиолдолд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоох, зохих ял шийтгэл оногдуулахад шийдвэрлэх үүрэгтэй. Энэ талаар профессор Г.Гантөмөр “Гэмт хэрэг үйлдсэн сэдэлт нь түүнийг хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангид тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид урьдчилан заасан бол зөвхөн тухайн гэмт хэргийн хувьд субъектив талын заавал байх (амьдралд үйлдэгдсэн хэрэгт заавал тогтоох, гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөх) үндсэн шинж болно” (Гантөмөр, Г., 2020, хууд. 268) хэмээн оновчтой тайлбарласан байдаг.

Зорилго ба сэдэл зэрэг субъектив талын нэмэгдэл шинжүүдийг аливаа зүйл ангийн диспозицид хуульчлах үндсэн шалтгаан, шаардлага нь тухайн зүйл ангид тодорхойлсон зан үйлийг илүү бүрэн гүйцэд, нарийн тодорхойлох явдал юм. Хүний зан үйл, үйл ажиллагаа нь зөвхөн гадаад нөхцөл байдлаас бус, дотоод сэтгэл зүйн хүчин зүйлсээс ихээхэн хамаардаг. Хууль эрх зүй, ёс зүйн хүрээнд хүний үйлдлийг үнэлэхэд зорилго, сэдэл чухал

үүрэг гүйцэтгэдэг. Сэдэл нь зан үйлийн учир шалтгаан болдог. Хүнийг ямар нэгэн зүйлд хүргэдэг дотоод хөдөлгөгч хүч, өөрөөр хэлбэл, өдөөгч нь сэдэл юм.

Сэдэл нь хүний үйл ажиллагааны бодит тусгал бөгөөд түүнийг үйл ажиллагаанд уриалан дуудаж байдаг өдөөгч, үйл ажиллагааг нь чиглүүлэн идэвхжүүлдэг хүчин зүйл, түүнд идэвхтэйгээр татан оролцуулагч хүний сэтгэл санааны өдөөгч, тэмүүлэл болно (Гантөмөр, Г., 2020, хууд. 268). Иймд хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийн сэдлийг тусгайлан хуульчлах нь уг гэмт хэргийг илүү нарийвчлах, гэмт этгээдэд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай тогтоох, мөн эрдэм шинжилгээний мэтгэлцээн өрнүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулна.

Хууль сахиулагчийн өдөр тутмын үйл ажиллагаа нь нийгэмд шударга ёсыг тогтоох, дэг журмыг сахиулах, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх чиглэгддэг. Эдгээр хууль ёсны үйл ажиллагааг гүйцэтгэснийх нь төлөө хууль сахиулагчдыг хараан зүхэх, өс хонзон санах тохиолдол цөөнгүй. Энэхүү сэдэл нь зөвхөн хууль сахиулагчийн албан үүрэгтэй холбоотойгоор төрж болохоос гадна энгийн иргэд хоорондын бусад харилцаанаас улбаатай байдлаараа хүний зан үйлд түгээмэл илэрдэг хандлага юм. Нэг жишээг дурдахад, шүүгдэгч Ц нь иргэн Ж-г “өөрийг нь алах гэж байна” хэмээн өсөрхөн, түүнийг алах зорилгоор 1994 оны 7 дугаар сарын 9-ний өдөр иргэн Ж-ийн оршин суудаг орон сууцны цонхоор бензин цацан, галдан шатааж, Ж, А нарын амь насыг хохироосон гэмт хэрэг үйлджээ. Шүүгдэгч Ц мэдүүлэгтээ “1994 оны 7 дугаар сарын 9-нөөс 10-нд шилжих шөнө 00 цагийн үед гэрээсээ шүдэнз авч Жамцаагийнхнийг шатаахаар явсан. Би түүний эхнэртэй гэр бүлийн харилцаатай байсан юм. Түүний нөхөр нь мэдээд “намайг ална гэж байна” гэж хэлэхээр нь миний уур их хүрч, тэднийд их тус болдог байсан, бараг бүх ажил төрлийг нь хийж өгч байсан зэргээ санаж, намайг ална, шулна гэсэн байхаар нь “шатаая...” гэж бодоод шөнө очиход гэр нь дотроосоо цоожтой байсан. Белорусснаас бензин авах гээд дөхөж очиход, хажуу талын амбаарын үүдэнд хувин байхаар нь түүнийг авч, туслах мотороос нь хувингийн талаас доош хэмжээний бензин авч, байшингийн араар нь тойрч очоод, том цонх нь онгорхой болохоор нь түүгээр бензинээ цацаад, араас нь шүдэнз зурж шидсэн. Миний үйлдсэн хэрэг үнэн. Надад хэлэх зүйл алга” хэмээн мэдүүлжээ. Дархан-Уул аймгийн эрүүгийн шүүхээс шүүгдэгч Ц-г “бусад өсөрхөж хонзогносон, олон хүний амь биед аюул учруулж болох арга хэрэглэсэн, хоёр хүнийг санаатай алсан” зэрэг хүндрүүлэх нөхцөл байдал агуулсан хэмээн үзээд, шүүгдэгчийг 15 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ (Таслан шийдвэрлэх тогтоол, 1995). Энэ мэтээр өс хонзонгийн сэдлээр хүний амь насыг хохироох гэмт хэрэг түгээмэл үйлдэгддэг. Гэвч хууль тогтоогч энэ нөхцөл байдлыг харгалзалгүйгээр, хууль сахиулагчийг алах гэмт хэргийг зөвхөн эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбож үзсэнээрээ гэмт этгээдийн тухайн үйлдэлдээ хандаж буй сэтгэхүйн харьцаа, тухайн үйлдэлд хөтөлж буй өдөөгчийг орхигдуулжээ.

Гэтэл өс хонзонгийн сэдлээр хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэрэг ч мөн үйлдэгдэж байсныг түүхэн баримт гэрчилнэ. Тодруулбал, иргэн Баттөмөр нь урьдчилан хорих байранд хоригдож байхдаа 1990 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 21 цагийн үед жижүүрийн сэргийлэгч Батжаргалыг ажил үүргээ гүйцэтгэж байхад нь сүлжиж томсон уяагаар хоолойг нь боож, амь насыг нь хөнөөхийг завдсан гэмт хэрэг үйлджээ. Гэрч Батбаяр мэдүүлэгтээ “Баттөмөр камертаа орж ирээд “Батжаргалыг эхлээд нэг боосон чинь тасарсан, дахиад боосон чинь тасарчихлаа. Хоолойг нь боогоод унагачих байсан юм...” гэж ярьж байсан. Баттөмөр эхнэртэйгээ уулзаж орж ирээд “Батжаргал тавтай уулзуулсангүй. Хонох байсан юм...” гэх мэтийн зүйл ярьж байсан. Үүнээс болсон болов уу гэж бодож байна” гэж мэдүүлсэн байна. Харин шүүгдэгч Баттөмөр “1990 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Батбаярт Баяраа гэгчийн оруулсан 2 шил архийг Батбаяр бид хоёр уусан. Тэгээд удалгүй манай авгай хорихын хойгуур ирсэн. Балсанжав намайг эхнэртэй минь уулзуулсан. Чимгээтэй уулзаж байхад Батжаргал хаалган дээр ирээд “хурдал, хурдал” гээд байсан. ...Би Батбаярт “Батжаргалыг нэг боосон уяа тасарчихлаа, дахиад боосон чинь мөн тасарчихлаа, хоолойг нь боогоод унагачих байсан юм...” гэж ярьж байсан нь үнэн” хэмээн мэдүүлжээ. Шүүхээс

Баттөмөрийг цагдаагийн байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүний амь биед халдах гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцож, түүнд 5 жилийн хугацаатай хорих ял оногдуулсан байна (Таслан шийдвэрлэх тогтоол, 1990). Энэ тохиолдолд шүүгдэгч Баттөмөр нь жижүүрийн сэргийлэгч Батжаргалд “эхнэртэй тавтай уулзуулсангүй” гэх шалтгаанаар өс хонзон санаж, улмаар амь насанд нь халдсан байна.

Олон улсын жишигт, хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо тухайн үйлдлийн зорилго, сэдлийг хэрхэн тусгасныг харьцуулан судлах нь зүйтэй.

Хүснэгт 1. Хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийг зарим орны Эрүүгийн хуульд тусгасан байдал

1	Бүгд Найрамдах Казакстан Улсын эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийг хуульчилсан байдал
	380-1 дүгээр зүйл. Хууль сахиулах, төрийн тусгай байгууллага, цэргийн албан хаагч, амьтны аймгийг хамгаалах улсын байцаагч, тусгайлсан байгууллагын анчин-байгаль хамгаалагчийн амь насанд халдах 1. Хууль сахиулах, төрийн тусгай байгууллага, цэргийн албан хаагч, амьтны аймгийг хамгаалах улсын байцаагч, амьтны аймгийг хамгаалах мэргэжлийн байгууллагын байцаагч, анчин-байгаль хамгаалагч болон тэдгээрийн ойр дотны хүнийг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан, эсхүл албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө өс хонзон санаж, амь насанд халдсан өөрөөр хэлбэл, амь насыг нь хөнөөх санаатай үйлдэл хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр арван жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг: 1) хоёр буюу түүнээс дээш хүний эсрэг; 2) хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, түүнчлэн хүнийг хулгайлах буюу барьцаалах гэмт хэрэгтэй хавсран; 3) хохирогчийг жирэмсэн болохыг мэдсээр байж; 4) онц харгис хэрцгийгээр; 5) бусад хүний амь насанд аюултай аргаар; 6) бүлэглэн, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай гэмт бүлэг; 7) өөр гэмт хэргийг нуун дарагдуулах эсхүл хялбарчлах зорилгоор, түүнчлэн хүчиндэх эсхүл бэлгийн шинжтэй хүчирхийллийн үйлдэлтэй хавсран; 8) удаа дараа; 9) хохирогчийг насанд хүрээгүйг мэдсээр байж; 10) онц байдал зарласан газар нутагт эсхүл терроризмын эсрэг ажиллагаа явуулж буй бүсэд; 11) онц байдал зарласан нөхцөлд эсхүл нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед үйлдсэн бол эд хөрөнгийг хураах арван таван жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих буюу бүх насаар нь хорих ялаар шийтгэнэ (Уголовный кодекс Республики Казакстан,, 2025).
2	Бүгд Найрамдах Беларусь Улсын эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийг хуульчилсан байдал
	362 дугаар зүйл. Дотоод хэргийн байгууллагын албан хаагч, цэргийн албан хаагчийг алах Дотоод хэргийн байгууллагын албан хаагч, цэргийн албан хаагчийг нийтийн хэв журам хамгаалах үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан алсан бол арван хоёр жилээс хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авах ялаар шийтгэнэ (Уголовный кодекс Республики Беларусь,, 1999).
3	Бүгд Найрамдах Азербайжан Улсын эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийг хуульчилсан байдал
	287 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх болон мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа этгээдийн амь насанд халдах

	Шүүгч, түүнчлэн прокурор, мөрдөн байцаагч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа этгээд, өмгөөлөгч, шинжээч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, түүнчлэн тэдгээрийн ойр дотны хамаатан садных нь хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор эсхүл ийм үйл ажиллагааны төлөө өш хонзон санаж, шүүхэд хэрэг, холбогдох материалыг хянан хэлэлцэж байх, эсхүл урьдчилсан мөрдөн байцаалт явуулж байх буюу шүүхийн шийдвэр, бусад актын биелэлтийг гүйцэтгэж байх үед амь насанд нь халдсан бол арван дөрвөөс хорин жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ (Уголовный кодекс Азербайджанской республики., 1999).
4	Бүгд Найрамдах Украин Улсын эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийг хуульчилсан байдал
	348 дугаар зүйл. Хууль сахиулах байгууллагын ажилтан, нийтийн хэв журам болон хил хамгаалах нийгэмлэгийн гишүүн болон цэргийн албан хаагчийн амь насанд халдах Хууль сахиулах байгууллагын ажилтан буюу түүний ойр дотны хүнийг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан, түүнчлэн нийтийн хэв журам болон хил хамгаалах нийгэмлэгийн гишүүн болон цэргийн албан хаагчийг нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан алах, эсхүл алахыг завдсан бол есөөс арван таван жил хүртэл хугацаагаар хорих буюу бүх насаар нь хорих ялаар шийтгэнэ (Уголовный кодекс Украины., 2001).
5	Бүгд Найрамдах Туркменистан Улсын эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийг хуульчилсан байдал
	231 дүгээр зүйл. Хууль сахиулах байгууллагын ажилтан болон цэргийн албан хаагчийг алахаар заналхийлэх, эсхүл хүч хэрэглэх Хууль сахиулах байгууллагын ажилтан, цэргийн албан хаагч, тэдгээрийн ойр дотнын хүмүүсийн эсрэг эрх зүйн хэв журам хамгаалах үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан алахаар заналхийлсэн, эсхүл амь биед нь аюултайгаар хүч хэрэглэсэн бол тогтоосон суурь хэмжээнээс арваас гучин нэгжтэй тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ (Уголовный кодекс Туркменистана., 1997).
6	Оросын Холбооны Улсын эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь насанд халдах гэмт хэргийг хуульчилсан байдал
	317 дугаар зүйл. Хууль сахиулах байгууллагын алба хаагчийн амь насанд халдах Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор, эсхүл ийм үйл ажиллагааны төлөө өс хонзон санаж, хууль сахиулах байгууллагын алба хаагч, цэргийн албан хаагч, түүнчлэн тэдгээрийн ойр дотнын хүмүүсийн амь насанд нь халдсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлаж, арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ (Уголовный кодекс РФ., 1996).

Казакстан (380-1 дүгээр зүйл): “Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан, эсхүл албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө өс хонзон санаж, амь насанд халдсан...” гэж тодорхой заасан байна. Энэ нь хууль сахиулагчийн өмнөх үйлдэлтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэргийг онцгойлон авч үзэж байгааг харуулна. Өс хонзон нь гэмт хэргийн гол сэдэл болж, энэ зүйлийн дагуу яллах үндэслэл болдог байна.

Беларусь (362 дугаар зүйл): Энэ зүйлд “Дотоод хэргийн байгууллагын албан хаагч, цэргийн албан хаагчийг нийтийн хэв журам хамгаалах үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан алсан бол...” гэж заасан байна. Хэдийгээр “өс хонзон” гэдэг үг тодорхой дурдагдаагүй ч, “үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан” гэдэг нь өмнөх үйлдэлтэй холбоотой сэдлийг агуулж болно. Тухайн этгээд хууль сахиулагчийн албан үүрэгтэй холбоотойгоор өс хонзон санаж, тэр үүргийг нь гүйцэтгэсний төлөө алсан бол энэ зүйлээр хариуцлага хүлээлгэдэг ажээ.

Азербайжан (287 дугаар зүйл): “Шүүгч, түүнчлэн прокурор, мөрдөн байцаагч... хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор эсхүл ийм үйл ажиллагааны төлөө өш хонзон санаж...” гэж тодорхой заасан байна. Энэ нь өс хонзонгийн сэдлийг маш тодорхой тусгасан бөгөөд шүүх, мөрдөн байцаалтын ажилтнуудын аюулгүй байдлыг хангах

зорилготой юм. Тэдний хийсэн ажилтай холбоотойгоор өшөө авах оролдлогыг онцгой хүнд гэмт хэрэгт тооцдог.

Украин (348 дугаар зүйл): “Хууль сахиулах байгууллагын ажилтан буюу түүний ойр дотнын хүнийг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан... алах, эсхүл алахыг завдсан бол...” гэж заасан Беларусь улстай нэгэн адил, “албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан” гэдэг нь өс хонзонгийн сэдэлтийг давхар агуулж болно. Хууль сахиулагчийн үүрэгтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэрэг нь энэ зүйлээр шийтгэгддэг.

Туркменистан (231 дүгээр зүйл): Энэ зүйл нь алахаар заналхийлэх, хүч хэрэглэхийг хуульчилсан бөгөөд “эрх зүйн хэв журам хамгаалах үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан” гэж заасан нь мөн л өс хонзонгийн сэдэлтийг шууд заагаагүй ч, хууль сахиулагчийн үүрэгтэй холбоотой үйлдлийг хуульчилсан байна.

ОХУ (317 дугаар зүйл): “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор, эсхүл ийм үйл ажиллагааны төлөө өс хонзон санаж, хууль сахиулах байгууллагын алба хаагч... амь насанд нь халдсан бол...” гэж маш тодорхой заасан байна. Казакстан, Азербайжантай адил өс хонзонгийн сэдлийг гэмт хэргийн бүрэлдэхүүний чухал шинж тэмдэг болгон тусгасан онцлог ажиглагдаж байна.

Казакстан, Азербайжан, Оросын Холбооны Улсууд нь “өс хонзон санаж” гэдэг сэдлийг тухайн зүйлийн үндсэн бүрэлдэхүүнд шууд тусгасан байна. Энэ нь тухайн гэмт хэрэг хууль сахиулагчийн албан үүрэгтэй холбоотойгоор үйлдэгдсэн болохыг онцгойлон тодотгож, субъектив талын шинжийг нарийн гаргаснаараа бусад (дээр харьцуулсан) орнуудын холбогдох хуулийн заалтаас илүү дэвшилттэй хэмээн үзэх үндэстэй.

Беларусь, Украин, Туркменистан зэрэг улсууд “албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан” гэсэн ерөнхий томъёоллыг ашигласан нь өс хонзонгийн сэдэлтийг шууд заагаагүй ч, энэ хүрээнд ойлгогдох боломжтой. Гэвч эдгээр улсуудын холбогдох зүйл заалтад зөвхөн холбогдол (связь)-ыг чухалчлан үзэж байна.

Манай улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсгийн зохицуулалт нь мөн адил зөвхөн холбогдлыг тогтооход чиглэдэг. Тодруулбал, “эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж” гэдэг нь тухайн үүрэг гүйцэтгэж байх үетэй шууд хамаарах эсхүл маш ойрын хугацааны холбоог илэрхийлж болох эрсдэлтэй. Иргэн Т.Лундаагийн жишээнээс харахад, цагдаагийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байх үедээ халдлагад өртсөн боловч, гэмт этгээдийн зорилго нь өмнө үйлдсэн гэмт хэрэг (зөрчил)-т хүлээлгэх хариуцлагаас зайлсхийх зорилготой байсан. Хэрэв хууль сахиулагчийг тэтгэвэрт гарсан хойно нь өмнөх албан үүрэгтэй нь холбоотойгоор үүссэн байсан өс хонзонгийн сэдлээр амь насанд нь халдсан бол одоогийн хуулийн томъёолол бүрэн дүүрэн хамгаалж чадахгүй байх эргэлзээтэй нөхцөл байдал үүснэ. Иймд гэмт хэргийн субъектив талын нэмэгдэл шинжүүд болох сэдэл, зорилго нь тухайн гэмт үйлдлийг зөв зүйлчилж, зохих ял шийтгэл оногдуулахад цаг хугацаанаас үл хамааран шийдвэрлэх үүрэгтэй хэвээр байна.

Өс хонзонгийн сэдэл нь хууль сахиулагчийн өмнөх албан үүрэгтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэргийг онцгойлон тодотгож, гэмт этгээдийн хувийн зан авир, сэтгэцийн байдлыг илэрхийлдэг. Иргэн Баттөмөрийн жишээ нь “эхнэртэй тавтай уулзуулсангүй” гэх хувийн өс хонзонгийн сэдлээр хууль сахиулагчийн амь насанд халдахыг завдсан тохиолдлыг харуулж байгаа нь энэ сэдлийг хуульчлах зайлшгүй шаардлагатайг баталж байна.

Профессор С.Жанцан “Өс хонзон санах нь хохирогч хууль бус, ёс суртахуунгүй үйл ажиллагаагаараа өсөрхөгч этгээд болон түүний ойр дотнын эрх, ашиг сонирхлыг хөндөж, тодорхой гэм хор учруулсан, эсхүл тийм байдал үүсэх нь тодорхой байснаас үүсдэг сэдэлт

юм. Харин хохирогч хуульд нийцсэн, шударга, зарчимч үйл ажиллагаагаараа өсөрхөгч этгээдийн буруу үйлдэл (эс үйлдэхүй)-д саад учруулснаас хариу барих, гомдол, хорслоо тайлах зорилгоор гэмт хэрэг үйлдэх нь илүү хор аюул ихтэй байдаг. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 17-д “албаны үйл ажиллагаа, бусад олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан хүнийг өөрийг нь буюу түүний ойрын төрөл, садангийн хүнийг алсан бол ялыг онц хүндрүүлэх нөхцөл байдал болгон” заасан нь агуулгаараа хуульд нийцсэн албан шударга үйл ажиллагаанд хорсож, дургүйцэж алж байгаа болохоор өс хонзонгийн нэг хэлбэр юм” (Жанцан ., С., 2009, хууд. 538) хэмээн маш оновчтой тайлбарласан.

Өс хонзонгийн сэдлийн эрх зүйн агуулгыг тодруулах нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад чухал байдаг бөгөөд Монгол Улсын Дээд шүүхээс гаргасан тайлбар нь энэхүү сэдлийг хэрхэн ойлгох, бусад ижил төстэй нөхцөл байдлаас ялгах суурийг тавьсан. Тухайлбал, Дээд шүүхийн тогтоолд “өс хонзон гэдэгт хохирогчийн хэлсэн үг, хийсэн үйлдэлд гэмт этгээд өөрийнх нь үзэл бодол, үнэлэмжид нийцээгүй гэж дургүйцэн гомдож, түүнээс хариу авах, хорсол тайлах гэсэн санаа зорилгыг ойлгоно. Энэхүү сэдэлт нь зөвхөн гэмт этгээд хохирогч хоёрын хоорондын харилцаанаас гадна үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, шашин шүтлэг, үзэл бодол, гаднах төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдал, цусан өшөө зэргээс үүссэн байж болно. Харин хувийн таарамжгүй харьцааны улмаас хүнийг санаатай алсан бол өс хонзонгийн сэдэлтээр хүнийг санаатай алсан гэж үзэхгүй” (Дээд шүүхийн тогтоол, 2009) хэмээн заасан.

Гэвч, өс хонзонгийн сэдлийн ийм өргөн хүрээний тодорхойлолт нь өмнөх хууль тогтоомжийн хүрээнд, ялангуяа 2002 оны Эрүүгийн хуульд уг сэдлийг хүндрүүлэх нөхцөл байдлаар хуульчилсан үед практик хүндрэлүүдийг үүсгэж байсан. Энэ талаар профессор С.Жанцан “Хүнийг алах гэмт хэрэг нь гол төлөв ахуйн хүрээнд, гэмт хэрэг үйлдсэн этгээд хохирогч хоёрын хооронд бий болсон таарамжгүй харьцаанаас үүдэлтэй өс хонзонгийн сэдэлтээр үйлдэгддэг болохоор хууль тогтоогч өс хонзонгийн сэдэлтээр хүн алахыг хүндрүүлэх нөхцөл байдалд хамааруулсан явдлыг хэтэрхий өргөн хүрээтэй, оновчгүй зохицуулалт” (Жанцан ., С., 2009, хууд. 538) гэж үзээд, үүнийхээ үндэслэл болгож “Учир нь практикт үүнээс болж хүндрүүлэх нөхцөл байдалгүй хүнийг санаатай алах гэмт хэрэг бараг гарахгүйд хүрнэ” (Жанцан ., С., 2009, хууд. 538) гэсэнтэй санал нэг байна.

Хууль тогтоогчийн 2015 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо сэдэл, зорилгын үүргийг шинэчлэн авч үзсэн нь эрүүгийн эрх зүйн орчин үеийн чиг хандлага, гэмт хэргийн шинж чанарыг илүү нарийвчлан ойлгох үзэл санаатай нийцсэн байж болох юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйл буюу “Хүнийг алах” гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд “өс хонзон”-гийн сэдлийг шууд заагаагүй нь энэхүү хандлагын илрэл гэж үзэж болно.

Эрүүгийн эрх зүйн онолд сэдэл нь гэмт хэргийн субъектив талын зайлшгүй байх шинж биш, харин ял шийтгэл оногдуулах үед харгалзан үздэг нөхцөл байдал, эсвэл зарим тусгай бүрэлдэхүүнд заавал байх шинж байж болно гэсэн зарчим үйлчилдэг (Оюунбилэг, 2019). Хууль тогтоогч “өс хонзон”-гийн сэдлийг 10.1 дүгээр зүйлийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд шууд багтаагаагүй нь дараах хэд хэдэн үндэслэлтэй байж болох юм. Нэгдүгээрт, гэмт хэргийн нийгэмд аюултай байдлыг бодитоор үнэлэх: “Өс хонзон” гэх сэдэл нь иргэд хоорондын харилцаанаас үүдэлтэй гэмтэл учруулах, алах зэрэг гэмт хэргүүдийн нийтлэг өдөөгч хүчин зүйлүүдийн нэг байдаг. Хэрэв ийм нийтлэг сэдлийг бүх тохиолдолд шууд хүндрүүлэх бүрэлдэхүүн гэж үзвэл, гэмт үйлдлийн нийгэмд аюултай байдлын жинхэнэ зэргийг бодитоор үнэлэх боломжийг хязгаарлаж, хэт хавтгайруулсан байдалд хүргэж болзошгүй (Цэрэндорж, 2018). Иймээс хууль тогтоогч сэдлийг гэмт хэргийн төрлөөс хамааран, зөвхөн тухайн гэмт хэргийн онцлогт тохирсон тохиолдолд л хүндрүүлэх нөхцөлөөр тодорхойлохыг зорьсон байж болно. Хоёрдугаарт, ял шийтгэлийн

хувийн шинж чанар ба шударга ёс: Эрүүгийн эрх зүйн гол зарчмуудын нэг бол ял шийтгэлийн хувийн шинж чанар буюу гэмт этгээдэд тухайн гэмт хэргийг үйлдсэн гэм буруугийн хэмжээнд тохирсон ял оногдуулах явдал юм (Доржготов, 2015). “Өс хонзон” гэх сэдэлтэй үйлдсэн бүх аллагыг шууд хүндрүүлэн үзэх нь гэмт этгээдийн гэм буруу, гэмт үйлдлийн шинж чанар, хохирогчийн хандлага зэрэг бусад хүчин зүйлсийг харгалзан үзэх боломжийг багасгаж, зарим тохиолдолд шударга бус ял оногдуулахад хүргэж болзошгүй. Тиймээс хууль тогтоогч “өс хонзон”-гийн сэдлийг ялыг хүндрүүлэх нөхцөл байдал (Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйл)-ын хүрээнд үнэлэх, эсхүл тусгай бүрэлдэхүүнт гэмт хэрэгт (жишээлбэл, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт – эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж...) онцгойлон авч үзэх замаар илүү уян хатан, шударга хандлагыг баримталсан байж болох юм.

Гэсэн хэдий ч, “өс хонзон”-гийн сэдлийн агуулга, түүний үүсгэдэг нийгэмд аюултай байдлын зэрэг нь гэмт хэргийн объектоос хамаарч ялгаатай үнэлэгдэх ёстой. Ялангуяа, хууль сахиулагчийн эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж, өөрийг нь болон түүний ойр дотнын хүнийг алах гэмт хэргийн тухайд “өс хонзон”-гийн сэдэл нь тухайн гэмт үйлдлийг онцгойлон ялгах, нийгмийн аюулын шинжийг зөв харгалзан үзэх, улмаар Эрүүгийн хуульд бие даасан зүйл ангиар зохицуулах зайлшгүй шаардлагатайг дараах үндэслэлүүд нотолж байна. Үүнд:

1. Төрийн эрх мэдэл ба хуулийн засаглалыг хамгаалах: Хууль сахиулагч нь төрийн эрх мэдлийг төлөөлөн, хууль ёсны дэг журмыг хангах үндсэн үүргийг гүйцэтгэдэг субъект юм. Түүний албан үүрэгтэй нь холбоотойгоор үүссэн “өс хонзон”-гийн сэдлээр үйлдсэн гэмт хэрэг нь зөвхөн хувь хүний амь нас, эрүүл мэндэд халдах бус, харин төрийн эрх мэдэл, хуулийн засаглалын эсрэг чиглэсэн ноцтой халдлага болдог. Энэ нь нийгмийн хэв журмыг алдагдуулах, төрийн институцэд үл итгэх байдлыг үүсгэх зэрэг өргөн хүрээний сөрөг үр дагавартай.

2. Гэмт үйлдлийн нийгэмд аюултай байдлын өндөр зэрэг: Профессор С.Жанцангийн тайлбарласнаар, хохирогч хуульд нийцсэн, шударга, зарчимч үйл ажиллагаагаараа гэмт этгээдийн буруу үйлдлийг таслан зогсоосноос үүдэх өс хонзон нь "илүү хор аюул ихтэй" байдаг. Хууль сахиулагчийн эсрэг үйлдэгдсэн “өс хонзон”-гийн сэдэлтэй гэмт хэрэг нь энэ тодорхойлолтод яг таарч байна. Иргэн Баттөмөрийн жишээ нь “эхнэртэй тавтай уулзуулсангүй” гэх хувийн өс хонзонгоор хууль сахиулагчийн амь насанд халдахыг завдсан нь албан үүрэгтэй нь холбоотой өс хонзонгийн сэдэл нь хэчнээн ноцтой, аюултай болохыг тодорхой харуулж байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь хууль сахиулагчдын аюулгүй байдлыг алдагдуулж, тэдний ажлын үр нөлөө, нийгмийн үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөх аюултай.

3. Урьдчилан сэргийлэх ба ялын зорилго: Ийм төрлийн гэмт хэргийг бие даасан зүйл ангиар хуульчилж, “өс хонзон санаж” гэх сэдлийг үндсэн бүрэлдэхүүнд нь шууд заах нь иргэдэд хууль сахиулагчийн албан үүрэгт халдаж болохгүйг илүү тодорхой сануулж, урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлнэ. Мөн гэмт этгээдэд үйлдсэн гэмт хэргийнх нь нийгэмд аюултай байдлын зэрэгт тохирсон, хатуу шийтгэл оногдуулснаар ялын шударга ёсны зарчим, гэмт үйлдлийг давтан үйлдэхээс сэргийлэх зорилго хангагдана.

4. Олон улсын жишиг: Олон улсын эрүүгийн эрх зүйн практикт төрийн албан хаагчийн албан үүрэгтэй нь холбоотой үйлдэгдсэн гэмт хэргүүдэд илүү хүндрүүлсэн хариуцлага хүлээлгэдэг нийтлэг хандлага байдаг. Энэ нь төрийн тогтвортой байдал, хуулийн хэрэгжилтийг хангахын тулд зайлшгүй шаардлагатай юм.

Дүгнэлт

Монгол Улсын Эрүүгийн хуульд “хууль сахиулагчийн эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж, өөрийг нь эсхүл түүний ойр дотны хүнийг алах” гэмт хэргийг тусгай, бие даасан зүйл анги болгон хуульчилж, уг зүйлийн үндсэн бүрэлдэхүүнд “урьд

үйлдсэн гэмт хэрэг, эсхүл зөрчилд хүлээлгэх хариуцлагаас зайлсхийх” зорилгоос гадна “өс хонзон санаж” гэх нэр томъёог шууд заах нь хуулийн засаглалыг бэхжүүлэх, хууль сахиулагчдын аюулгүй байдлыг хангах, мөн гэмт хэргийн нийгэмд аюултай байдлыг бодитоор үнэлж, шударга ёсыг тогтоохын тулд зайлшгүй шаардлагатай эрх зүйн шийдэл мөн. Энэ нь гэмт хэргийн сэдэл, зорилгын онолын ач холбогдлыг практикт зөв тусгасан, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ач холбогдолтой.

Санал

Судалгаанд үндэслэн, хууль сахиулагчийн амь насанд халдах үйлдлийг хүнийг алах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлаас салган, Эрүүгийн хуулийн тусгай ангид тусад нь бие даасан зүйл болгон хуульчилж, зорилго, сэдлийг тодорхой заах нь зүйтэй хэмээн үзэж байна. Энэ нь уг гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг бүрэн тодорхойлж, хууль сахиулагчдын аюулгүй байдлыг хамгаалах төрийн бодлогыг илүү тодорхой болгоно.

Бие даасан, шинэ зүйл ангид дараах зорилго, сэдлийг заавал байх шинжээр хуульчлах шаардлагатай. Үүнд:

- “...хууль ёсны үйл ажиллагаанд нь саад учруулах зорилгоор...”;
- “урьд үйлдсэн гэмт хэрэг, эсхүл зөрчилд хүлээлгэх хариуцлагаас зайлсхийх зорилгоор”;
- “...албан үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан, эсхүл үүргээ гүйцэтгэснийх нь төлөө өс хонзон санаж...”.

Ашигласан материал

1. Боженко, С. (2017). *Комментарий к Уголовному кодексу Российской Федерации*. (Рарог, А.И. хян.). Москва.
2. Векленко, С. Б., & Бавсун. (2006). *Уголовно-правовая оценка субъективной стороны состава преступления: Учебное пособие*. Омск.
3. Гантөмөр, Г. (2020). Гэмт хэргийн бүрэлдэхүүн. Г. Г.-О.-О. Гантөмөр-Д, *Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. Сурах бичиг*. Улаанбаатар.
4. Гантөмөр, Г. (2011). *Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол*.
5. Доржготов, Б. (2015). *Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги*. МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
6. Дээд шүүхийн тогтоол, Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай. (Монгол Улсын дээд шүүх. 2009 оны 05 22).
7. Жанцан, С. (2009). *Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. Гэмт хэргийн тухай сургааль. I боть*. Улаанбаатар.
8. Кизилов, А. (2002). *Уголовно-правовая охрана управленческой деятельности представителей власти. Монография*. Ульяновск.
9. Козаченко, И. Н., Незнамовая, & Новоселов. (1998). *Уголовное право. Особенная часть*.
10. Нарангэрэл, С. (1999). *Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги*. Улаанбаатар.
11. Оюунбилэг, Н. (2019). Гэмт хэргийн бүрэлдэхүүн дэх субъектив талын асуудал. *Хууль зүйн сэтгүүл*, 3(45), хуудсд. 25-31.

12. Постановление Президиума Верховного Суда РФ. (2005). *Об изменении приговора, смягчении назначенного наказания с учетом конкретных обстоятельств совершения преступлений и раскаяния осужденного, действия которого обоснованно квалифицированы по ч. 3 ст. 30, п. «и» ч. 2 ст. 105, ст. 317 УК РФ.*
13. Самундра, П. &, & Бямбадорж. (2021). *Эрүүгийн эрх зүйн үндэс*. Улаанбаатар: Хууль сахиулахын их сургууль.
14. Саруханян, А. (2003). *Преступления против порядка управления. Учебное пособие для вузов*. Ставрополь.
15. Содовсүрэн, Б. (1998). *Монгол Улсын эрүүгийн эрх зүй*. Улаанбаатар.
16. Таслан шийдвэрлэх тогтоол, 47 (Дархан хотын 1 дүгээр хэсгийн ардын шүүх 1990 оны 12 26).
17. Таслан шийдвэрлэх тогтоол,, Дугаар 5. (Дархан-Уул аймгийн шүүх. 1995 оны 03 14).
18. Уголовный кодекс Азербайджанской республики, (1999 оны 12 30). https://continent-online.com/Document/?doc_id=30420353#pos=3527;-51-ээс Гаргасан
19. Уголовный кодекс Республики Беларусь, (1999 оны 07 09).
20. Уголовный кодекс Республики Казахстан, (2025 оны 09 16). https://online.zakon.kz/Document/?doc_id=31575252&pos=6286;-78#pos=6286;-78-ээс Гаргасан
21. Уголовный кодекс РФ,, "Уголовный кодекс Российской Федерации" от 13.06.1996 N 63-ФЗ (ред. от 31.07.2025) (с изм. и доп., вступ. в силу с 01.09.2025). (1996 оны 06 13).
https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/a475165485713e1bcc4e7a7b14c332d42821e59a/-ээс Гаргасан
22. Уголовный кодекс РФ, (1996 оны 06 13).
23. Уголовный кодекс Туркменистана, (1997 оны 06 12). https://online.zakon.kz/Document/?doc_id=31295286&pos=1987;-46#pos=1987;-46-ээс Гаргасан
24. Уголовный кодекс Украины, (2001 оны 04 05).
25. Цэрэндорж, Д. (2018). *Албан тушаалын гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх нь*. Улаанбаатар: Адмон принтинг.
26. Шабанов, А. (2003). *Охрана жизни и здоровья сотрудника правоохранительного органа (уголовно-правовая и криминологическая характеристика)*. дис. ... канд. юрид. наук. Ростов н/Д.
27. Шишко, И. (огноо байхгүй). *Уголовное право. Особенная часть. Учебник*.
28. Шүүхийн шийтгэх тогтоол, 2019/ШЦТ/537 (Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2019 оны 06 04).
29. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №07 (2015 оны 12 03).